МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 12 өдөр Дугаар А/440 Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, 9.3.10, Эрүүл ахуйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.5, 4.1, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 31 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төвийн Мөрөн сумын Хог хаягдлын нөхцөл байдал хүндэрч байгаль орчин болон иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх хэмжээнд хүрсэнтэй холбогдуулан, "Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв" ХХК-аас ирүүлсэн хүсэлтийг харгалзан "Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв" ХХК –ийн Нийгмийн даатгалын шимтгэлийн өр барагдуулахад 136,865,674 (Нэг зуун гучин зургаан сая найман зуун жаран таван мянга зургаан зуун далан дөрвөн) төгрөг, "Нэмэн" ХХК-д үүссэн шатахууны өр барагдуулахад 134,413,331 (Нэг зуун гучин дөрвөн сая дөрвөн зуун арван мянга гурван мянга гурван зуун гучин нэгэн) төгрөг, нийт 271,279,005 (Хоёр зуун далан нэгэн сая хоёр зуун далан есөн мянга таван) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 271,279,005 (Хоёр зуун далан нэгэн сая хоёр зуун далан есөн мянга таван) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3. "Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв" ХХК –ийн Нийгмийн даатгалын шимтгэлийн өр барагдуулах 136,865,674 (Нэг зуун гучин зургаан сая найман зуун жаран таван мянга зургаан зуун далан дөрвөн) төгрөг, "Нэмэн" ХХК-д үүссэн шатахууны өр барагдуулах 134,413,331 (Нэг зуун гучин дөрвөн сая дөрвөн зуун арван мянга гурван мянга гурван зуун гучин нэгэн) төгрөг, нийт 271,277,005 (Хоёр зуун далан нэгэн сая хоёр зуун далан есөн мянга таван) төгрөгийг зориулалтын дагуу зарцуулахыг "Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв" ХХК (С.Мөнх-Эрдэнэ)- д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М. Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА Ш. ИДЭРБАЯСГАЛАН

6710011707